



Глоб Интернэшнл  
ТББ

## "ХҮНИЙ ЭРХИЙН МЭДЭЭЛЛЭЭР ДАМЖУУЛАН ИРГЭНИЙГ ЧАДАВХЖУУЛАХ НЬ" ТӨСЛИЙН ХҮРЭЭНД БЭЛТГЭВ



Их Британий  
ЭСЯ

Глоб Интернэшнл ТББ, "Хүний эрх, хөгжил" төв, Монголын ТББ-ын форум

# САНАЛ

## НИЙТИЙН ЭРХ АШГИЙГ НЭХЭМЖЛЭН ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ ХЭРЭГТЭЙ БАЙНА

"Нийтийн эрх ашиг", "нийтийн эрх ашгийн хэрэг" гэдэг нь, үр нөлөө нь ганц хүнд бус, олон нийтэд хамаатай, тухайлбал, нийтийн эрүүл мэнд, хэрэглэгчдийн эрх, амьжиргааны түвшин, байгаль орчин, түүний баялаг, үр шимиийг хүртэх, соёлын өвийг хамгаалах зэрэг асуудлыг ойлгоно. Тийм ч учраас нийтийн эрх ашгийн стратегийн өмгөөллийн үр нөлөө нь олон хүнд хүрч үйлчлэн хууль ёс, шударга ёсыг нийгэмд төлөвшүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулдаг.

Монгол улсад шинэ тутам хөгжиж буй нийтийн эрх ашиг (НЭА)-ийн өмгөөллийн хэргүүд дээр ажиллаж ирсэн цөөн ТББ хамтран НЭА-ийг хамгаалж нэхэмжлэх нээлттэй эрхийн асуудлыг анх гарган тавьснаар зарим хууль, эрх зүйн зохицуулалт хийгдсэн. Тухайлбал, "Байгаль орчныг хамгаалах тухай хууль"-д 2010 оны 7 сард орсон нэмэлт өөрчлөлтөөр "байгаль орчны хохирлыг нэхэмжилж сум, дүүргийн Засаг даргаас гадна сонирхсон иргэд, байгаль орчныг хамгаалах дүрмийн зорилго бүхий ТББ-үүд нийтийн эрх ашгийг хамгаалан шүүхэд нэхэмжлэх эрхтэй" болсон. Мөн ХЭХТ-ийн хуульчдын санаачлагаар 2008 онд Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөлийн дэргэд "Нийтийн эрх ашгийн стратегийн өмгөөллийн хороо" байгуулагдаж, одоогоор 100 гаруй өмгөөлөгчийг эгнээндээ нэгтгээд байна.

Гэвч НЭА-ийг нэхэмжлэн хамгаалах үйлсэд олон бэрхшээл тулгарч байна. Үүний хамгийн том нь НЭА-ийн өмгөөллийг дэмжсэн хууль, эрх зүйн орчин хангартгүй, онцолбол "**НЭА-ийг хамгаалж нэхэмжлэх эрх**" (*Open standing*)-ийг **нийтлэг түвшинд олгох** асуудал болно. НЭА-ийг хамгаалж нэхэмжлэх эрхийг нээлттэй байдлаар олгосон, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр орсон заалтаас харвал, зөвхөн байгаль орчныг хамгаалах дүрмийн зорилго бүхий ТББ л шүүхэд нэхэмжлэх эрхтэй байна. Гэтэл НЭА-ийн асуудал нь зөвхөн байгаль орчны асуудлаар хязгаарлагдахгүй тул НЭА-т хамаарах бусад асуудлаар ТББ-үүд, бие даасан хуульчид, өмгөөлөгчид шүүхэд өөрсдийн нэрийн өмнөөс нэхэмжлэл гаргах эрх олгосон хуулийн зохицуулалтыг бий болгох хэрэгтэй юм. Үүнийг ТББ-ын тухай хууль, Өмгөөллийн тухай хууль, хэрэг хянан шийдвэрлэх процессын хуулиудад тусгаж өгөх нь зүйтэй.

**Бусад улс оронд** нийтийн эрх ашгийг хамгаалж нэхэмжлэх эрхийг Үндсэн хууль, салбарын хуулиудаараа баталгаажуулсан байdag нь нийтийн эрх ашгийн төлөө ажилладаг хуульчид, ТББ-уудыг стратегийн өмгөөлөл хийхийг нь зоригжуулж, нийгмийг дэвшилттэйгээр өөрчлөхөд чухал үүрэг гүйцэтгэдэг. Мөн нийтийн эрх ашгийг тодорхой салбарт хамгаалан нэхэмжлэх нээлттэй эрхийг хүлээн зөвшөөрсөн **олон улсын гэрээ конвенцууд** ч бий. Тиймээс Монгол улс ТББ-ын тухай хуулийн шинэчилсэн найруулгад НЭА-ийн өмгөөллийг дэмжих чиглэлээр дараах зохицуулалтыг тусгах нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

- Нийгэмд үйлчилдэг ТББ-ыг бусдаас ялгаж буй "Нийгэмд ашиг тустай үйл ажиллагаа" хэмээх ойлголтод "нийтийн эрх ашгийг хамгаалан шүүхэд нэхэмжлэх үйл ажиллагаа"-г онцгойлон хамруулах
- Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагын хувьд дүрэмд заасан үйл ажиллагааны чиглэлээр олон нийтийн эрх ашгийг хамгаалан төрийн байгууллага, албан тушаалтан, шүүхэд гомдол, нэхэмжлэл гаргах эрхийг нь хуульчлан олгох (Зөвхөн магадлан итгэмжлэгдсэн, нийгэмд үйлчилдэг байгууллагад л энэ эрхийг олгохгүйгээр)
- НЭА-ийн өмгөөлөл хийдэг ТББ-үүд, хуульчдын энэ төрлийн үйл ажиллагааг дэмжих санг бий болгох, сангийн хөрөнгийг зарцуулах журамд нь зохицуулалт хийх. Үүнд, хуульчдыг сургах, мэргэшүүлэх, өмгөөллийн зардлын бүрэн болон хэсэгчлэн хариуцах гэх мэт.
- Нийгэмд үйлчилдэг ТББ-аас нийтийн эрх ашгийг хамгаалан шүүхэд нэхэмжлэхд нь улсын тэмдэгтийн хураамжаас нь чөлөөлөх зохицуулалтыг бий болгох (Тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.13-т нэмэлтээр оруулах)
- НЭА-ийн өмгөөлөл хийдэг, Өмгөөлөгчдийн холбооны гишүүн өмгөөлөгчдийг бүх талаар дэмжих, Үүнд: ТББ-д ажилладаг өмгөөлөгчдийн гишүүнчлэлийн татварыг хөнгөлөх, чөлөөлөх, түүнчлэн энэ чиглэлээр дагнан ажилладаг өмгөөлөгчдийг Өмгөөллийн хуулиар хүлээлгэсэн үүрэг болох "жилд 2-оос доошгүй иргэнийг үнэ төлбөргүй өмгөөлөх" үүргээс нь чөлөөлөх зэрэг зохицуулалтуудыг бий болгох нь зүйтэй юм.